	Шинж	Эрчим	Магадлал	Тархалт	Хугацаа	Нөхөн сэргээгдэх боломж	Дүн, хэмжээ
Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөлөл							
Төслийн үйл ажиллагаа, машин техник, тоног төхөөрөмжийн дуу чимээ, хөдөлгөөнөөс амьтад дайжин амьдрах орчин өөрчлөгдөх	-1	3	2	2	3	-1	-9
Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд амьдарч шавж, жижиг хөхтөн амьтад шууд сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй.	-1	2	3	1	3	0	-9
Зарим зүйлийн шавьж, сээр нуруугүйтэн амьтдыг тоо толгой буурах	-1	3	3	1	3	0	-10
Зэрлэг амьтдын амьдрах орчин, нутагшил, байршил, үржилд нөлөөлөх	-1	3	2	1	3	0	-9
Орон нутгийн идээшилтэй бэлчээрийн хөхтөн амьтдад амьдрах орчин, үржилд үзүүлэх нөлөө	-1	2	2	1	3	0	-8
Байнгын нутагшилтай шувуудад үзүүлэх нөлөө	-1	1	2	1	3	0	-7
Уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор уурхайн ажиллагсад болон шинээр шилжин ирэгсэд ан амьтдыг хулгайгаар агнаж болзошгүй	-1	1	1	1	1	0	-4
Шатах тослох материалын хадгалалт, бохирын болон хогийн цэгийг зохих журмын дагуу байрлуулж ашиглаагүйн улмаас амьтан хордох, өвчлөх сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй	-1	3	3	2	1	0	-9

Дүгнэлт: Уурхайн ашиглалтын үед үүсэх нөлөөллийг үнэлж үзэхэд том хөхтөн болон зэрлэг ан амьтан, мөлхөгч, мэрэгч, шувуунд дундаас их эрчимтэй сөрөг нөлөөтэй байна. Сөрөг нөлөөллийг бууруулах, зайлсхийх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр төслийн зүгээс амьтдын амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл урт хугацаанд бага зэрэг буюу ноцтой хэмжээнд биш гэж үзэв.

3.4. Орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөлөл

Төслөөс орон нутгийн хүн амд үзүүлэх нөлөөллийг ажил эрхлэлт, амьжиргаа, шилжилт хөдөлгөөн, нүүлгэн шилжүүлэлтийн хувьд авч үзжээ.

Алтны шороон ордыг ашиглах төсөл хэрэгжсэнээр сумын түвшинд ажил эрхлэлт, үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэж үүнийг дагаад иргэдийн амьжиргаанд эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Мөн уурхайг урьдчилсан байдлаар 2 жилийн хугацаанд ашиглах бөгөөд орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөлөл нь урт хугацааны шинж чанартай байхаар байна.

3.5. Орон нутгийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл

Төсөл хэрэгжсэнээр нөлөөллийн бүсийн сумын эдийн засагт дараах байдлаар шууд болон шууд бус эерэг нөлөөллүүд үзүүлнэ.

Эдгээрт:

- Ажил эрхлэлт нэмэгдэх,

- Уурхайд бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлснээр орлого нэмэгдэх, иргэдийн амьжиргаа сайжрах,
- Сумын орлогын эх үүсвэр бэхжих,
- Бизнес хөгжихөд таатай орчин бүрдэх

3.6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨ


Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд ямар нэг түүх, соёлын өв, дурсгал зүйлс байхгүй тул сөрөг нөлөө тодорхойлогдохгүй.

Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед археологийн болон палеонтологийн ховор түүх соёлын дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.

3.7. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨ

Төслийн талбайн ойр орчимд улсын тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй бөгөөд төсөл хэрэгжиж буй талбай нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгуудтай давхцалгүй байна.

Баянхонгор аймагт нийт найман Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд байх ба Жаргалан суманд Заг байдрагийн голын эхэн сав-БЦГ байна. Төслийн талбай нь улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.



Зураг 3. Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд

БҮЛЭГ-4. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

4.1. 2026 ОНЫ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго: “ЖАМП” ХХК-ийн “Бөөрөгийн ам” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго оршино.

“Бөөрөгийн ам” алтны шороон ордыг ашиглах уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **74,092,500.0** төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Үүнд:

- ✓ Агаарын чанар, хөрсөн бүрхэвчид төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- ✓ Байгаль орчныг хамгаалахад хяналт тавих хугацаа, хариуцах эзэнийг тогтоох,
- ✓ Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох,
- ✓ БОМТ-ий дагуу үйл ажиллагаа явуулахад дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүдийг тодорхойлох,
- ✓ Мэргэжлийн байгаль орчны ажилтантай байх,
- ✓ БОМТ-ий тайлан болон БОМТ-ний хэрэгжилтийг цаг тухай бүрд холбогдох байгууллагуудад хүргүүлэх, тайлагнах, хүлээлгэн өгөх шаардлагатай.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгааллын ажил хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулийн дээрх шаардлагын дагуу “Бөөрөгийн ам” нэртэй алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

4.2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
-	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаарын чанар								
1.1	Үйлдвэрээс ажилчдын амрах байр хүртэлх түрж тэгшилсэн шороон замаар зорчих үед хурд хэтрүүлэн явснаар тоосжилт үүснэ	Хурдны заалтын тэмдэг тавих	Шороон зам	ш	100,000.00	4	400,000.00	Үйл ажиллагаа эхлэх үед	- MNS 4597:2013 - Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага.
1.2	Дотоод замыг салхи ихтэй, хуурайшилттай өдрүүдэд 2 л/м2 нормоор усалж байх, зам талбайн тоос босох гадаргууг хөрс барьцалдуулагч бүхий усаар шүрших	Замын усалгаа хуурайшилттай үед хийх		Дотоод үйл ажиллагааны зардлаар	-	-	-	Тоос шороо ихээр боссон, хуурайшилттай үед	- Байгаль орчны сайдын 2015 оны А301 дүгээр тушаал
-	Зардлын дүн				-	-	400,000.00	-	-
2	Гадаргын ба газрын доорх усны нөөц								
2.1	Бөөргийн голын усны урсцыг хамгаалах, сэргээх	Гадаргын болон газрын доорх усыг хамгаалах талаар ордын нөхцөлд тохирсон цогц бодлогыг хэрэгжүүлэх, төлөвлөгөө боловсруулан мөрдөн ажиллах	Бөөргийн гол	-	1,000,000.00	1	1,000,000.00	2026 онд	- Усны тухай хууль

		Ажилчдын аюулгүй ажиллагааны дүрэмд ус хамгаалах тухай тусгаж өгөх	Уурхайн ажилчид	-	-	-	-	2026 онд	- Ус ашигласны төлбөрийн тухай хууль
		Зуны улиралд аадар борооны үед үер болох нөхцөлтэй тул уурхай, овоолго зам талбай усанд автаж болзошгүй тул үерийн уснаас хамгаалах, усыг хатуу хог хаягдлаар бохирдуулахгүй байх хамгаалалтын далан шуудуу барих арга хэмжээ авах	Уурхай	-	360,000.00	1	360,000.00	2026 онд	- Усны бохирдлын төлбөрийн журам
		Байгалийн гэнэтийн эрсдэлийг урьдчилан тооцох, учирсан тохиолдолд яаралтай арга хэмжээний хөтөлбөр боловсруулах	Уурхай	-	-	-	-	2026 онд	- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
		Ахуйн хэрэглээнээс гарах бохир ус цэвэрлэх септик систем суурилуулах	Уурхай	ТЭЗҮ-д тусгасан уурхайн магадлаагүй ажлын зардлаас авах			-	2026 онд	
-	Зардлын дүн				-	-	1,360,000.00	-	-
3	Хөрсөн бүрхэвч								
3.1	Газрын чанар доройтох, эвдрэх, бохирдох	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх	Уурхайн эзэмшлийн талбайд	Үйл ажиллагааны зардлаас			-	2026 онд	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам
3.2	Уурхай талбай хүртэл сайжруулсан шороон зам тавьснаар ул хөрс эргэсэн сул шороо ихтэй унаган төрхөө алдсан	Уурхайн талбай болон шороон замын 2 талаар орон нутагт ургах боломжтой мод, бут тарих	Уурхайн талбай, зам дагуу	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөгөөр			-	2026 онд	- MNS 6141:2011 - Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага.
-	Зардлын дүн				-	-	-	-	-

4		Ургамлын нөмрөг							
4.1	Талбай доторх ургамлын нөмрөг устаж үгүй болох сөрөг нөлөөлөлтэй	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг орон нутгийн БОГ, газрын даамал нартай зөвшилцөн мод тарих газрыг сонгох	Орон нутаг	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төлөвлөгөөнд шаардагдах зардал тусгагдсан			-	2026 онд	-
-	Зардлын дүн			-	-	-	-	-	
5		Байгалийн гамшиг, аваар осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх							
5.1	Уурхайн осол гэмтэл, тоног төхөөрөмжийн саатал зэрэгт ажиллагсад өртөх, хариу арга хэмжээ авч чадахгүйгээс үүдэн эрүүл мэндэд нь хохирол учрах	Уурхайн бүх ажилтнуудыг ХАБЭА-н болон галын аюулгүй ажиллагааны сургалтад хамруулах, өдөр бүр ажилд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч байх	Нийт ажиллагсдад	Үйл ажиллагааны зардлаас			-	Үйл ажиллагааны тур	-
5.2	Байгалийн гамшгаас үүсэх нөлөөлөл	Гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдах	Уурхайн барилга байгууламж	-	4,500,000.00	1	4,500,000.00	2026 онд	- Гамшгийн тухай хууль
-	Зардлын дүн			-	-	-	4,500,000.00	-	-
6		Галын аюулаас урьдчилан сэргийлэх							
6.1	Гал түймрийн эрсдэл үүсэх	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрмийг үйл ажиллагааны турш мөрдөн ажиллах	Үйлдвэрийн хэмжээнд бүх ажилчид	Дотоод зохион байгуулалтаар			-	Үйл ажиллагааны тур	- Галын аюулгүй байдлын дүрэм
		Галын дохиоллын системийг ашиглах, галын булан байгуулах	Үйлдвэрийн хэмжээнд	-	2,500,000.00	1	2,500,000.00	2026 онд	

6.2	Гамшгийн үеийн бэлэн байдлын талаар судлаагүй ажилчид гамшгийн нөлөөлөлд өртөх	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг онцгой байдлын хэлтэстэй хамтран баталж, бүх ажиллагсдыг сургалтад хамруулах.	Нийт ажиллагсдад	-	100,000.00	1	100,000.00	2026 онд	
-	Зардлын дүн				-	-	2,600,000.00	-	-
7	Ажиллагсдын эрүүл ахуйн талаар								
7.1	Уурхайн технологийн горим, үйл ажиллагаа нь ажиллагсдын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй.	Ажиллагсдын жилд 2 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц үзлэгт хамруулах Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Нийт үйлдвэрийн ажиллагсад	ХАБЭА-н зардлаар санхүүжүүлнэ			-	2026 онд	- ХАБЭА-н заавар журам, стандарт
-	Зардлын дүн				-	-	-	-	-
-	Нийт	-	-	-	-	-	8,860,000.00	-	-

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд 2026 онд нийтдээ 8.86 сая төгрөг зарцуулахаар төлөвлөвөө.

4.3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Жамп” ХХК нь “Бөөрөгийн ам” алтны шороон ордод 2026 онд нийтдээ 9.12 га талбайд ашиглалтын үйл ажиллагаа явуулна. Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 2026 онд өмнөх жилүүдэд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн 1.83 га талбай болон шинээр олборлолтод өртөх талбайд бүрэн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 13. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
-	1	2	3	4	5	6	7	8
1	Техникийн нөхөн сэргээлт	Шимт хөрс хуулалт, хадгалалт	га	9.12	1,250,000.00	11,400,000.00	2026 онд	- MNS 5916:2008 - Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт, - MNS 5917:2008 - Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага. - MNS 5918:2008 - Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага.
		Дотоод овоолгын нөхөн сэргээлт	га	9.12	1,588,815.79	14,490,000.00	2026 онд	
		Ашигласан талбайг түрж тэгшлэх, биологийн нөхөн сэргээлтэд бэлдэх	га	10.95	993,607.31	10,880,000.00	2026 онд	
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсөөр хучилт хийх	га	10.95	496,803.65	5,440,000.00	2026 онд	
		2025 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд олон наст ургамлын үр суулгаж биологийн нөхөн сэргээлт хийх	га	1.83	254,794.52	466,273.97	2026 онд	
		2026 онд шинээр олборлох талбайд олон наст ургамлын үр суулгаж биологийн нөхөн сэргээлт хийх	га	9.12	254,794.52	2,323,726.03	2026 онд	
3	Татан буулгах, хаалтад бэлдэх	Төлөвлөх шаардлагагүй	-	-	-	-	-	-
-	Нийт	-	-	10.95	3,080,082.14	45,000,000.00	-	-

“Жамп” ХХК нь 2026 онд нөхөн сэргээлтийн ажилд нийтдээ 45.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

4.4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэдэг нь төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ.

2026 онд Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Жаргалант сумын засаг даргын санал болгосны дагуу тус сумын 3-р багийн нутагт орших Цохиотын рашааныг хамгаалах хайс хамгаалалт хийж ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж нийт 9.0 сая төгрөг зарцуулахаар тусгалаа.

Мөн Жаргалант сумын 3-р багийн нутагт ойн цэвэрлэгээний ажлыг 10 га газарт гүйцэтгэх бөгөөд энэ ажилд 1.0 сая төгрөг зарцуулна.

Хүснэгт 14. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хамгааллын арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
-	1	2	3	4	5
1	Жаргалант сумын 3-р багийн нутаг дахь Цохиотын рашааныг хамгаалах хайс хамгаалалт хийх	1 цэг	9,000,000.00	9,000,000.00	2026 онд
2	Жаргалант сумын 3-р багийн нутагт ойн цэвэрлэгээ хийх	10 га	100,000.00	1,000,000.00	2026 онд
-	Нийт	-	-	10,000,000.00	-

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардалд 2026 онд нийтдээ 10.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөвөө.

4.5. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

2026 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөх шаардлагагүй болно.

4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс, археологи, палеонтологийн олдвор тогтоогдоогүй.

Цаашид уурхайн олборлолтын үйл ажиллагааны явцад ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс, булш, бунхан, хиргисүүр зэрэг археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд Соёлын өвийг хамгаалах үүднээс төслийн үйл ажиллагааг түр зогсоож хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад хандаж мэдэгдэл хүргүүлж ажиллана.

4.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“ЖАМП” ХХК-ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсдын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 15. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
-	1	2	3	4	5	6	7	8
1	Байгалийн аюул гамшиг							
1.1	Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах	Байгалийн аюул гамшиг	1	250.00	250.00	Жил бүр	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003-(сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012.05.17)
2	Галын аюул							
2.1	Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах	Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал гарсан тохиолдолд унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах	Галын аюул эрсдэл	5	1,000,000.00	5,000,000.00	Жил бүр	MNS 5390:2004, ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
2.2	Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах	Уурхайн болзошгүй үерээс хамгаалах байгууламж (суваг, шуудуу, далан хаалт) барих	Галын аюул эрсдэл	Үйл ажиллагааны зардлаар	-	-	Жил бүр	Галын аюулгүй байдлын тухай хууль, /шинэчилсэн найруулга/ Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

3 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар								
3.1	Төслийн үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сэргөөр нөлөөлөх	Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинар тогтмол зохион байгуулах, хамруулах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардлаар		-	Жил бүр	- MNS 4968:200 “ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага” MNS 4995:2000 “ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” - MNS ISO 13688:2000 “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага” - MNS 5010:2001 “ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” - MNS 5105:2001, “ХАБ. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” - MNS ILO OSH 1:2003, “ХААЭА-н удирдлагын тогтолцооны талаарх удирдамж”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
		Ослын үед ашиглах ИТА, ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж сургалт явуулах	Төслийн талбайд	5	100000	500,000.00	Жил бүр	
		Болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардлаар		-	Жил бүр	
		Болзошгүй аваар ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах	Төслийн талбайд	10	193,725.00	1,937,250.00	Жил бүр	
		Ажилтан бүрийг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардлаар		-	Жил бүр	
		Болзошгүй осол аюулын үед орон нутгийн эмнэлэг болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар тохиролцож гэрээ байгуулан ажиллах	Төслийн талбайд	Гэрээний дүнгээр		-	Жил бүр	
-	Нийт	-	-	-	-	7,437,500.00	-	-

4.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй. Хог хаягдлыг энгийн, ахуйн, аюултай гэх мэтээр Монгол улсын Хог хаягдлын тухай хуульд заасан бөгөөд эдгээрийг хэлбэрээр нь хатуу, шингэн, хийн гэж ангилав.

Энгийн хог хаягдал гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг хэлнэ.

Ахуйн хог хаягдал гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг хэлнэ.

Энэхүү төслийн БОННУ-ний тайлангийн 5.9-д хог хаягдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийн тусгасан байна. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг 2017 онд батлагдсан Хог хаягдлын тухай хуулийн үзэл баримтлал, зүйл заалтыг үндэслэн боловсруулжээ.

Хүснэгт 16. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
-	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад байршуулах	Энгийн хог хаягдлаас үүсэх нөлөөллийн бүс	ш	100,000.00	10	1,000,000.00	2026 онд	- Хог хаягдлын тухай хууль; - А/349 тушаал, Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл;
		-		-	-	-	Үйл ажиллагааны туршид		
		Хог, хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах, сэргээн засварлах	Хог хаягдлын цэг	ш	500,000.00	1	500,000.00	Үйл ажиллагааны туршид	

		Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах	Төслийн талбай	-	-	-	-	Үйл ажиллагааны туршид	- БОАЖ-ын сайдын 2017 оны А/368 тушаал Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал;
		Хатуу хог хаягдлыг зориулалтын битүүмжилсэн саванд хадгалж, байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагын тогтоосон цэгт зайлуулж байх	Төслийн талбайд	-	-	-	-	Үйл ажиллагааны туршид	- БОАЖ-ын сайдын 2018 оны А/445 тушаал. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар;
2	Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн явцад гарсан аливаа хог хаягдлыг аюултай болон энгийн хаягдалд ангилан ялгаж байх	Уурхай, үйлдвэр	-	-	-	-	Үйл ажиллагааны туршид	- MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
3	Аюултай	Аюултай хог хаягдал зайлуулахаар тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулж хамтарч ажиллах, уурхайгаас ялгарч болох ажилласан тос масло, аккумулятор зэргийг журмын шаардлагад нийцүүлэн түр хадгалж гэрээт компанид хүлээлгэн өгөх	Аюултай хог хаягдал	Тодорхойлох боломжгүй			-	Үйл ажиллагааны туршид	БОАЖ-ын сайдын 2018 оны А/18 тушаал Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах;
-	Нийт	-	-	-	-	-	1,500,000.00	-	-

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд 2026 онд нийтдээ 1.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөвөө.

4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“ЖАМП” ХХК-ний алтны шороон ордыг ашиглах үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрд илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ.

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

“ЖАМП” ХХК нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал
-	1	2	3	4	5	6	7	8
1	Агаар							
1.1	Хүхрийн исэл SO2 Азотын давхар исэл NO2, Нүүрстөрөгчийн дутуу исэл CO Тоос PM 2.5, Тоос PM 10, Дуу чимээ, доргио	Ил уурхайн салхины чиглэлийн дээр, доор - тус бүр 1 цэг, Засварын газар - 1 цэг, Уурхайн тосгон - 1 цэг	Жилд 2 удаа	6	50,000.00	300,000.00	Жилд 2 удаа, 3 цэгт	Агаар мандлын сорьц авах ерөнхий шаардлага УСТ 3384-82, Агаарын чанар MNS 4585:2016, Дээжлэхдээ: УСТ 0017-2-5-12-1988, ISO 8186, УСТ 0017-2-5-11-1988, MNS 4048:1988, ISO 9855:1983, MNS 5002:2000

2 Гадаргын болон газрын доорх ус								
2.1	Ундны усны ерөнхий үзүүлэлт болон бактериологи тодорхойлох	Худгийн уснаас	Улиралд 1 удаа	4	92,500.00	370,000.00	-	- MNS 6148-2010, “Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, - MNS 4586:1998, “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага.
3 Хөрс, газрын гадарга								
3.1	Агрохимийн үзүүлэлтүүд (ялзмаг, рН, EC _{2.5} dS/m, P ₂ O ₅ , K ₂ O, CaCO ₃ , NH ₄ ,NO ₂ , NO ₃), Механик бүрэлдэхүүн (тоос,элс, шавар)	Машины зогсоол, Хог хаягдлын цэг, ШТМ-ын агуулах, Тосгон, Шимт хөрсний овоолго	Жилд 2 удаа	10	50,000.00	500,000.00	1 удаад 5 цэгт	- MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, - MNS 2305:1994 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам, - MNS 3310:1991 Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох арга, - MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ 1, 2-р хэсэг - MNS ISO 11269-1:2002 Хөрсний чанар. Хөрсний ургамал бохирдуулагч бодисын нөлөөллийг тодорхойлох
3.2	Хөрсний хүнд металл (Cr, Cd, Pb, Ni, Co гэх мэт)		Хавар, намрын улиралд 5 цэгт	5	25,000.00	125,000.00	1 удаад 5 цэгт	
-	Нийт	-	-	-	-	1,295,000.00	-	-

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 2026 онд нийтдээ 1.3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөвөө.

4.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“ЖАМП” ХХК-ний алтны шороон ордыг ашиглах үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Байгаль орчны асуудалд зөвхөн байгаль орчны мэргэжилтэн анхаарал хандуулах биш уурхай болон үйлдвэрийн бүхий л ажилтнуудын анхаарал хандуулах чухал асуудал юм. Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг байгаль орчны мэргэжилтэн хариуцан ажиллах бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

Хүснэгт 18. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			Сар 4, 5, 6	Сар 7,8,9	Сар 10,11,12		
-	1	2	3	4	5	6	7
1	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Тохиролцох	Үйл ажиллагааны туршид			Уурхайн удирдлага	-
2	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагааны туршид			Уурхайн удирдлага, Байгаль орчны мэргэжилтэн	-
3	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ-нд тайлагнах.	Үйл ажиллагааны зардлаар	-	-	11-р сар	Байгаль орчны мэргэжилтэн	-
-	Нийт	-	-	-	-	-	-

4.11. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

"ЖАМП" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 19. Олон нийтэд төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд		Тайлагнах, хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Зохион байгуулах газар
1	Аймгийн БОГ, БОУАӨЯ	Багийн ИНХ	Хуралд танилцуулах	БОМТ-ийн 2026 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ний өдрийн дотор	Жаргалант сум
		Аймгийн БОГ, БОХХБайцаагч	Уулзалт			Баянхонгор аймаг
2	Төрийн захиргааны төв байгууллага	БОУАӨЯ-т	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр болон файл хэлбэрээр	2027 оны БОМТ	12-р сарын 01-ний өдрийн дотор	Улаанбаатар хот

4.12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН НЭГТГЭЛ

“ЖАМП” ХХК-ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

“ЖАМП” ХХК нь “Бөөрөгийн ам” алтны шороон ордыг ашиглах төслийн 2026 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийтдээ 74,092,500.0 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө

Хүснэгт 20. Төслийн 2026 оны БОМТ-ний зардлын нэгтгэл

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8'860'000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	45'000'000.0
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	10'000'000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	7'437'500.0
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1'500'000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1'295'000.0
9	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
10	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
-	Нийт дүн	74'092'500.0

ДҮГНЭЛТ

Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутагт орших “ЖАМП” ХХК-ийн “Бөөрөгийн ам” нэртэй алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Алт олборлох үйл ажиллагаа явуулах явцад нөлөөлөлд голчлон өртөгч нь хөрс, ургамал, газрын гадарга ба геологийн тогтоц юм.

Иймд сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх ажлыг жил бүрийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заагдсан арга хэмжээг цаг тухайд нь гүйцэтгэж, үр дүнд нь дүгнэлт хийн ажиллах шаардлагатай.

“ЖАМП” ХХК нь 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийтдээ 74’092’500.0 (Далан дөрвөн сая ерэн хоёр мянга таван зуу) төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

“ЖАМП” ХХК нь 2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хуулийн 31-р зүйлд заасны дагуу БОМТ-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй.

Иймд 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын 50% буюу 37’046’250.0 (Гучин долоон сая дөчин зургаан мянга хоёр зуун тавь) төгрөгийг БОУАӨЯ-ны тусгай дансанд байршууллаа.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор Аймгийн байгаль орчны газар болон БОУАӨЯ-нд хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг томилогдсон ажлын хэсэг газар дээр нь хянаж үнэлсэн нэгдсэн дүн 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал төсөл хэрэгжүүлэгчээс боловсруулж ирүүлсэн дараа жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах нэг нөхцөл болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутагт орших “Бөөрөгийн ам” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах Техник, эдийн засгийн үндэслэл, 2025 он
2. Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутагт орших “Бөөрөгийн ам” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2025 он
3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”
4. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: www.legalinfo.mn
5. Байгаль орчны мэдээллийн сан: www.eic.mn